



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/14

Чингис хот

Шинэ Коронавирусын эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/78 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1 Албан хаагчдынхаа дархлааг дэмжиж, шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, халуун хэмжигчийг байршуулах, албан хаагчдадаа эрүүл мэндийн байгууллагын үнэн зөв мэдээллийг тогтмол шуурхай хүргэн, амны хаалтыг /маск/ тогтмол зүүлгэж, иргэдийг амны хаалттай /маск/ үйлчлүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Нутгийн удирдлагын ордонд үйл ажиллагаа явуулж буй байгууллагын удирдлагуудад даалгасугай.

2. Гаднаас нэвтэрч буй амны хаалт зүүсэн /маск/ иргэдийг нэвтрүүлэх, энэ талаар тухай бүр тэмдэглэл хөтөлж танилцуулах, өрөө тасалгааны цэвэрлэгээ, агааржуулалт, ариутгал халдваргүйтгэлийг зориулалтын бодис, уусмал ашиглан өдөр бүр хийж хэвшүүлэхийг Хэнтий Нийтлэг үйлчилгээ /Г.Баяржаргал/-д үүрэг болгосугай.

3. Цэцэрлэгийн насны /5 хүртэлх/ хүүхэдтэй албан хаагчдын нэрсийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын цэцэрлэгийн насны /5 хүртэлх/ хүүхэдтэй албан хаагчдыг хорио цээрийн дэглэм буурах хүртэл өглөөний 09:30 цагаас орой 16.30 цаг хүртэл богиносгосон цагаар ажиллахыг зөвшөөрсүгэй.

5. Дээрх албан хаагчдын тухайн хугацааны цалинг бүрэн тооцож олгохыг Нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

6. Аймгийн онцгой байдлын газраас байгууллагын амны хаалтны нөөцийг нэмэгдүүлэх чиглэл өгсөнтэй холбогдуулан ажилтнууддаа амны хаалтаар хангах нөөц бүрдүүлэх зорилгоор 644000 /зургаан зуун дөчин дөрвөн мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.

7. Хөрөнгө зарцуулалтын тооцоог 2 дугаар хавсралтаар баталсугай.

8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын  
2020 оны 02 дугаар сарын 17 өдрийн  
А/Н дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Цэцэрлэгийн насны /5 хүртэлх/ хүүхэдтэй албан хаагчдын нэрс

№	Нэр	Албан тушаал
1.	Ж.Гантулга	Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга
2.	Л.Бат-Октябрь	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
3.	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
4.	Э.Мөнх-эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
5.	Ч.Баярцолмон	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
6.	Б.Мөнгөнцэцэг	Архивын тасгийн эрхлэгч
7.	Д.Зоригтбаясгалан	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн менежер
8.	Д.Ганболд	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
9.	Ж.Саруултөгс	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
10.	Ж.Энхбат	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
11.	С.Оюун-Эрдэнэ	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
12.	С.Ган-Эрдэнэ	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
13.	Э.Түвшинтөгс	Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч
14.	Ц.Гэрэлтуяа	Архивын тасгийн Цахимжуулалт хариуцсан ажилтан
15.	Г.Эрдэнэтунгалаг	Архивын тасгийн Цахимжуулалт хариуцсан ажилтан
16.	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
17.	Ж.Цэнджав	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
18.	Г.Уянга	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
19.	Б.Оргодол	Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч
20.	Д.Цэцэгсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
21.	М.Дэлгэрзаяа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
22.	Б.Хулан	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
23.	Г.Ариунхүү	Нягтлан бодогч
24.	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
25.	Л.Цэнддорж	Цэргийн штабын офицер
26.	С.Галбадрах	Цэргийн штабын офицер

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
даргын 2020 оны ..... дугаар сарын .....  
өдрийн.....дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын зүйл	нэг бүрийн үнэ /төгрөг/	тоо ширхэг	нийт дүн /төгрөг/
1	Амны хаалт	5600	115	644.000
бүгд дүн				644.000